

Научная статья
УДК 811.512.31
DOI 10.18101/3033-1310-2024-3-48-56

Буриад аялгууны зарим хэлц үг оюуны соёлын баримт болох нь

© Лувсанцэрэн Цэрэнчимэд

доктор Ph.D.,

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Монгол Улс, 14191. Улаанбаатар хот, Бага Тойруу-14

Tserenchimed@msue.edu.mn

Хураангуй. Монгол хэлний үгийн сан баяжихаднутгийн аялгуу, түүнийөвөрмөц үгс, хэлц үг чухал үүрэгтэй. Энэ өгүүлэлд буриад аялгуугаар хэлэлцэгчдийн аман ярианд идэвхтэй хэрэглэгддэг зарим хэлц үгийн утга, хэрэглээний талаар авч үзэв. Хэлийг хэрэглэгчбид өдөр тутмын яриандаа тогтвортой нэгж, хэлц үгийг түгээмэл ашигладаг. Гэсэн хэдий ч эдгээр үгийг яагаад, ямар шалтгаанаар аман ярианд хэрэглэх болсон, тус хэлц үгийн утга санаа ямар түүхэн үйл явдал, уламжлалтсоёлтой холбогдохыг тэр бүртгөдөрхөй мэддэггүй. Эдгээр үгийн утга, хэрэглээ, соёлын онцлогийгзалуу үеийнхэн бүрэн дүүрэн ойлгодоггүй юм уу эсвэл бүр мэдэхгүй ч байх талтай. Тиймээс бид ардын аман зохиол болон эртний уран зохиол, орчуулгын зохиолын баримтаас хэвшсэн хэлц үгсийг онцлон үзэв. Улмаар тэдгээрийн утга, хэрэглээ, соёлын онцлогийг монголчуудын үнэт зүйлийн нэг төрөл, оюуны соёлын өв гэж үзэж тайлбарласан болно.

Түлхүүр үг. Хэлц үг, буриад аялгуу, аман ба бичгийн зохиол, ярианы хэл, хэмнэх зарчим, заншил

Для цитирования

Лувсанцэрэн Ц. Буриад аялгууны зарим хэлц үг оюуны соёлын баримт болох нь. Буриад хэл болон уран зохиол сургуульд. 2024. Дугаар 3. Н. 48–56.

Удиртгал. Тухайн нэг хэлэнд утга илэрхийлэх хоёр буюу түүнээс дээш нэгж, хэлний утга хэлбэрийн аль алианаар нэгдэн нийлж, бүрэлдүүлэгч үгсийг өөрчилж болохооргүй салшгүй бэхжин тогтвортой болсноор хэлц нэгжийг бүтээдэг гэх зарчмыг хэл шинжээч эрдэмтэн, судлаачид санал нэгтэй зөвшөөрдөг. Монгол хэлний хэлц нэгж нь монголчуудын ахуй амьдралын болоод сэтгэлгээний давтагдашгүй өвөрмөц онцлогийг хадгалсан, оюуны соёлын үнэт өв юм. Энэ талаар, В.Н.Телия: «Хэлц үгийн бүрэлдэхүүн, хэл, найруулга нь өөрийн үндэсний онцлогийг хэлний соёлын үүднээс тодорхойлох толь юм» [10, Н. 9], М.Базаррагчаа: «Хэл нь битүү ба задгай нэгж гэсэн тогтолцоотой. Агуулгын битүү нэгжийг хэлц үг гэх ба энэ нь гүн бүтцийн тогтвортой нэгж болж, тухайн ард түмний соёл, сэтгэхүй, ахуй заншлын өвөрмөц онцлогийг үеийн үед тогтвортой хадгалдаг учраас хэлний дархлаа болдог. Хэл нь тухайн үндэстний оюуны соёлын уламжлал, шинэчлэлийг хадгалагч эрдэнэсийн сан юм. Энэ нь монгол хэлний хэлц юм. Хэлний нэгжүүдийг соёлын үүднээс үзэхийг сүгээр (лингвокультурема) гэж болно» хэмээн [2, Н. 6, 8] тус тус тэмдэглэсэн байна.

Монгол хэлний хэлц үгийн судлал нь үгийн сангийн найруулга бүрэлдэхүүний нэг чухал хэсэг байдаг. Судлаачид хэлц үгийг утга, бүтцийн

ерөнхий байдлаар нь өвөрмөц ба хэвшмэл гэсэн ерөнхий ангиллыг баримталсаар иржээ.

Тухайлбал:

Өвөрмөц хэлц үг:	Хэвшмэл хэлц үг:
Үг тус бүрийн тодорхой утга алдагдсан, цөмөөрөө нийлж нэгэн утга санаа илтгэнэ.	Нэг хэсэг хэлцийн бүрэлдэхүүнд орсон үгийг утгын талаар задалж болох боловч утга бүхэлдээ шилжсэн, өөр юм үзэгдэлтэй зүйрлэсэн байдаг. [Ж.Төмөрцэрэн 2001:139;140]
Утга төгссөн санааг илэрхийлдэггүй, ухагдахууны шинжтэй, өгүүлбэрт нэг гишүүн болдог.	Зүйр цэцэн үг нь утга төгссөн санааг илтгэдэг, бие даасан өгүүлбэр болдог. [Г.Аким 1999:5]
Адилтгасан хэлц буюу өвөрмөц хэлц.	Эс адилтгасан хэлц буюу хэвшмэл хэлц. [М.Базаррагчаа 2003: 13]
Бодото фразеологизмууд мэдүүлэлэй ямар нэг гэшүүнэй үүргэ дүүргэдэг.	Тогтомол холбоото үгэнүүд (оньһон хошоо үгэнүүд) бүхэли мэдүүлэлнүүд болдог. [С.Г.Ошоров 2016:97]

Энэ мэтээр тухайн судалгааны ажлын зорилго, хүрэнээс шалтгаалан ялгаатай байдлаар томъёолсон олон санал, тодорхойлолтыг дурдаж болно. Мөн хэлц үгийг гарал үүсэл, утга, бүтэц, бүрэлдүүлэгч нэгжийнх нь онцлогт тулгуурлан хийсэн нарийвчилсан ангиллыг энд үл өгүүлж товчилжээ.

Монгол хэлний үгийн сан хэлц үгээр баялаг болоход нутгийн аялгуунууд үлэмж үүрэгтэй гэж үзэх бүрэн үндэстэй. Учир нь монгол хэлний үгийн санг далай тэнгис гэвэл түүнийг салбар аялгуунууд нь гол горхи лугаа адил тэтгэж, баялаг байх нэгэн зам нь болдог юм. Бид хэлийг хэрэглэгчийнхээ хувьд хэлц үгийг өдөр тутмын яриандаа ашигладаг, сайн муу, бүтэлтэй-бүтэлгүй юмны тухай өгүүлж буйг баримжаалж ойлгодог хэдий ч, яагаад? ямар учраас ийнхүү хэлэлцэх болсон хийгээд тэрхүү үгсийн цаана ямар түүх, заншил, соёлын улбаа хадгалагдаж байгааг тэр бүр нарийн тодорхойлж, тайлбарлаж чаддаггүй. Зарим хэлц үгийн ялангуяа өвөрмөц хэлц үгийн утгыг баримжаалах байтугай юун тухай өгүүлснийг таамаглах ч боломжгүй байх тохиолдол бий. Цаг хугацаа улиран өнгөрөхийн хэрээр энэ асуудал улам бүр тулгамдаж буйг зарим аялгуугаар хэлэлцэгчдийн өнөөгийн бодит байдлаас харж болно. Ер нь аливаа угсаатны оюуны соёл (аман зохиол, бичгийн зохиол)-ын илрэлийг судалдаг этнолингвистикийн салбар 20-р зууны 70-аад оноос төлөвшин хөгжсөн. Энэ дэгийг үндэслэгч Н.И.Толстой, славяны угсаа хэл шинжлэл гэсэн онолын суурь бүтээлээ туурвисан юм. Хэл шинжлэлд тулгуурлан хөгжсөн угсаатны хэл шинжлэл нь уламжлалт оюуны соёлын асуудлыг авч үзэхдээ хэлэнд гол биш ч гэлээ маш их анхаарч, хэл шинжлэлийн арга, онолын ойлголтыг өргөн хэрэглэдэг [11] гэжээ.

Энэ бичил судалгаанд буриад аялгуугаар хэлэлцэгчдийн аман ярианд идэвхтэй хэрэглэгдэж буй боловч нарийн учрыг төдийлөн ухаж мэддэггүй, дараа үеийнхэн мэдэхгүй болж буй хэдэн хэлц үгийн үүсэл, утга, хэрэглээний онцлогийг монголчуудын оюуны соёлын өв, үнэт зүйлийн тодорхой төрөл болох аман зохиол ба бичгийн зохиолоос үүтгэн товч тайлбарлахыг чухалчиллаа.

Үндсэн хэсэг. Хэлц үгсийн (энд өвөрмөц ба хэвшмэл хэлцийн аль алийг хамааруулав) үүсэл, тэдгээрийг хэлэлцэх болсон шалтгаан нь харилцан адилгүй байдаг. Зарим хэлц ёс заншлын улбаанаас, зарим нь түүхэн үйл явдал, цаг үетэй

холбоотой, нөгөө нэг хэсэг нь хүний үйлдэл, бодит явдлаас, өөр нэг нь аман зохиол, бичгийн зохиол, хууч яриа зэргээс үүдэн хэлний хэрэглээнд хэвшин тогтох нь түгээмэл ажээ. Монголчуудын дунд эртнээс нааш хэлэлцэж ирсэн баатарлаг тууль, үлгэр, сургаалын зо

Нэг. «Нэг зулаар хүүрлэхэ (ярих, өгүүлэх) ~ Нэг зулаар хэхэ» хэлц үгийн утга

Нэг зулаар ярих өгүүлэх, хийх — Энэ хэлцээр илэрдэг ерөнхий утга нь аль нэг үйл явдал тодорхой хугацаанд үргэлжилсэн төгсгөлөг цагийн харьцаа заана. **Тодруулбал:** Ямар нэг ажил үйл эрхлэх, хийж гүйцэтгэх эхлэл, төгсгөлтэй хугацааны утга илэрхийлнэ. Буддын шашинтнуудын бурхан шүтээнд тахил өргөх олон зан үйлийн нэг зул өргөх ёстой холбон хэлэлцэх болсон үг юм. Шүтээнд өргөсөн зул асааснаас эхлээд бөхөх хүртэл тодорхой мөчлөг хугацаанд бадамладаг. Удаан түргэн мандах нь цөгцний хэмжээнээс хамаарна. Тэгэхээр энэхүү хэлц үгийн гол санаа бол «тодорхой хугацаанд тасралтгүй үргэлжлэх» утга буюу «завсарлагагүй ярих», «ажлыг цаг алдалгүй түргэн хийж дуусгах» зэрэг болно. Уг хэлц буриад Гэсэрийн туужид дээрх байдлаар тохиолдож байна. Жишээ нь:

...Нарагүй балай дайдада
Ногоогүй хуурай дэлхэйдэ
Абай– Гэсэр абгынгаа
Гал-Нурман хаантай
Дайнай ехээр дайлалдаад
Дарагдан байхынь хараба
Тэрэ болоһон зэргые
Үзэн харан байхадаа,
Айзай Муузай хоёр
Гэрхэн тээшээ гүйдэбэ
Хан Хюрмас баабайдаа
Түргэн дундаа хүрэжэ
Нэг зулаар хүүрлэжэ (Tunk, San — үг)
Нэгэ амьяар хэлбэд...

(Гэсэр, Дүрбэдэхи халаа, «Гал Нурман хааные дараһан тушаа», 254-р тал)

...Наргүй балар талд
Ногоогүй хуурай дэлхийд
Абай Гэсэр авгынхаа
Гал Нурман хаантай
Дайтахын ихээр дайтаж
Дарагдаж байхыг нь харав.
Тэр болсон байдлыг
Үзэж харсан даруйдаа
Айзай Муузай хоёр
Гэр тийшээ гүйдэв.
Хан Хурмас эцэгтээ
Хурдан түргэн очиж
Нэг зулаар өгүүлж
Нэр амьсгаагаар хэлэв гэнэ...

Өнөөгийн буриад аялгуугаар хэлэлцэгчид аман ярианд «*тодорхой нэг ажил, үйлийг эхэлснээрээ дуусгах, түргэн хийх*» гэсэн утгаар түлхүү хэрэглэж, хэлэлцэж байна.

Хоёр. «Гайха ехэ», «Гайха тагна ехэ» хэлц үгийн тухай. *Гайха (тагна) ехэ*— Ямар гайхалтай, хачин сонин юм бэ? гэсэн утгаар хэлэлцдэг үг болно. Энэ хэлц үг хаанаас, юунаас үүдэж бий болсныг лавшруулаад үзэхэд буриад Гэсэрийн туужд уг хэлцийн үндсэн хэлбэр нь бүрэн байдлаар хэд, хэдэн бүлэгт тохиолдож байна. **Жишээлбэл:**

...Абай Гэсэр хүбүүнэй
Тала хара нюдэн
Танха (*цүлхгэр ширмэн ваар*) хара гүзээн
Болоод ябахын дээрэндэ
Дээдэ ехэ тэнгэришүүл
«Абай Гэсэр хүбүүнэй

...Абай Гэсэр хүүгийн
Тал хар нүдтэй
Тарган хар гүзээ
Болоод явахын үед
Дээд их тэнгэрүүл
«Абай Гэсэр хүүгийн

Аахилгаан дуулдахаа болибо,
Бэлыгэн хээр мориной
Түбэрөөн дуулдахаа болибо» гэлдэжэ
Гайхал ехээр гайхаба
Тагнал ехээр тагнаба
Гурбан хөөхэй эгэшэнрыень
«Бэдэрэгты!»— гэжэ элигээбэ.
Доодо замбида оруулба...

(*Гэсэр, хоёрдоху халаа, «Гэсэрэй дайда дээрэ түрэнэн тушаа», 167-р тал*)

...Гушан гурбан баатарынъ
Гурбан зуунхан хушуушадынъ
Гурбан мянган хяанарынъ
Тэрэ болоһон зэргые
Шагнан дуулан байхадаа
Гайхал ехээр гайхаба
Тагнал ехээр тагнаба
Хара ехэ ханаатай
Хара –Зутан ноён
Айхын ехээр айба
Эшэхын ехээр эшэбэ...

(*Гэсэр, гурбадаху халаа, «Гэсэрэй Архан хара шүдхэрые дараһан тушаа», 208-р тал*)

...Бахид булад
Бардай мүнгэн хэлмэнь
Өөрөө хуйһаан нугаржа
Гурбан хараанай газарта
Багса шаагдан унаба
Абай Гэсэр хүбүүн
Гайхал ехээр гайхажэ,
Тагнал ехээр тагнаба...

(*Гэсэр, дүрбэдэху халаа, «Гал Нурман хааные дараһан тушаа», 260-р тал*)

Аахилах нь сонсогдохоо болив
Билгийн хээр морины
Төвөргөөн сонсогдохоо болив» гэл-
цэж
Гайхахын дээдээр гайхав
Тагнахын дээдээр чагнав
Гурван хүүхэд эгч нараар нь
Хайж олуулахаар илгээв
Доод тив оруулав...

Гучин гурван баатар нь
Гучин гурван хошуучлагч нь
Гурван мянган хиа нь
Тийм болсон байдлыг
Сонсон чагнан байхдаа
Гайхахын дээдээр гайхав
Тагнахын дээдээр тагнав
Хар их санаатай
Хар Зутан (Цотон) ноён
Айхын дээдээр айв
Ичихийн дээдээр ичив...

...Бахим болд
Том мөнгөн сэлэм нь
Өөрөө хуйнаасаа сугарч
Гурван буудлын газарт
Бат зоолдон унав
Абай Гэсэр хүү
Гайхахын дээдээр гайхав
Тагнахын дээдээр тагнав...

Буриад Гэсэрийн тууж шүлэглэсэн хэлбэртэй бөгөөд энэхүү тэгш хэмт найруулга бүхий зэргэд өгүүлбэр нь аман ярианд хэлц үг болж хэвшихдээ ихээхэн хураангуй болжээ. Хэлний хэмнэх зарчмын тухай доцент П.Бямбасан: «Хэл бүрийн хөгжлийн нэгэн чухал зүй тогтол болсон хэлний хэмнэх эрмэлзэл дэлхийн олон хэлэнд зарим нь сайн, зарим нь тааруу дулим янз бүр хэрэгждэг байна. Хэлний хэмнэх эрмэлзэл нь хэлний системийн бүх түвшнийг хамрах бөгөөд хэлний хувьсал хөгжилд ихээхэн нөлөөлдөг учраас хэлний хам цагт ч зөв тодорхойлон тогтоход чухал ач холбогдолтой юм» гэж тодорхойлоод авиа, бүтээвэр, үг, өгүүлбэрийн түвшинд тайлбарлажээ. [3]

Гайха (тагна) ехэ — хэлц үгийн хувьд хэлэх аялгаар зэрэгцсэн зэргэд өгүүлбэр бүтнээрээ хураагдаж хэвшсэний үр дүн болох нь баримт жишээнээс тодорхой харагдав. Нөгөө талаас, бичгийн хэл, ярианы хэлний онцлог ч хамаатай. Ярианы хэл бичгийн хэлнээс уян налархайн дээр маш түргэн хувьсаж өөрлөгддөг [8, Н. 32], ярианд аль болох богино хураангуй өгүүлбэрүүд зонхилдог

зэрэг чанараас болж аман ярианд хураангуй хэлбэрээр хэвшин тогтсон нь илэрхий байна.

Гурав. «Туулайн шала ханагдаха» хэлц үгийн тухай. XIII зууны эхээр Сажа бандид Гунгаажалцан Субашид (*санскритаар Субашид радна ниди, төвөдөөр Лэгшэд ринбочей дэр, монголоор Сайн үгт Эрдэнийн сан*) хэмээх шүлэглэлийг төвөд хэлээр зохиожээ. Субашид бол монголд ихэд дэлгэрсэн зохиолын нэг юм. Цахар гэвш Лувсанчүлтэмийн орчуулсан Субашид, түүний тайлбарыг ХҮШ-ХІХ зууны үед Өвөр Монголд болон Буриадад хэвлэн гаргасан байна. [17, Н. 9, 16] Ийнхүү хэвлэсэн Субашид, түүний тайлбар үлгэрийн цоморлигийг ард түмэн амнаас ам дамжуулан хэлэлцэх болсон. Энэ хэлц үгийн үүсэл, утга, хэрэглээний талыг тодруулах үүднээс Сайн үгт Эрдэнийн сан Субашидын 4 дүгээр бүлгийн 117 дугаар бадаг:

*«Үнэнхүү цэцэн хүн өөрөө шинжиж мэдыюу
 Үй балай тэнэгүүд хүний үгийг дагаж явьюу
 Өтөлсөн зөнөг нохой дэмий балай хуцахад
 Өөр бусад ноход учиргүй гүйлдэн хуцьюу»*– ийн тайлбар үлгэрийг өгүүлэх хэрэгтэй болж байна.

Утга зохилдох үлгэр нь: *«Урьд нэгэн нуурын дэргэд хэдэн туулай байснаас усны хөвөөн дэх модны жимс нуурт унахад шал гэсэн дуу гарлаа. Түүнийг туулай сонсоод айж зугтан, үнэгтэй дайралдахад үнэг учрыг нь асуулаа. Туулай түүнд «Шал ирэв» гэсэнд үнэг бас зугтав. Тэр мэт уламжлан сонсоод маш олон гөрөөс өөр өөрийн, хэнээс сонссоноо дам дам хэлсээр туулайд тулахад туулай: «Тийм нэгэн газар ирэхийн чимээг би сонссон билээ.» гээд бүгдийг дагуулж тэр нуурын захад хүрээд хүлээж байтал нэгэн жимс унаад шал гэж дуугарсанд, туулай: «Өнөө шал ирэв. Энэ билээ.» гэхэд арслан түүнд хэлсэн нь: «Энэ нь жимс унахын дуу буй за. Та нар айх хэрэггүй» гэж бүгдийг амрууллаа гэдэг» хэмээх билээ. [17, Н. 135]*

Энэхүү хэлц үгийн гол санаа нь ямар нэг зүйл санаанд хүрэхгүй байх, голох, чамлах гэсэн утгаар илэрдэг. Бүхэл бүтэн үлгэрээс үүдэн, түүний санааг хураасан хэлц үг болж хэвшсэн нь сонирхолтой юм. Аймхай туулай «Шал ирэв» хэмээх аюулт хүчний тухай зарлаж, хамаг амьтны тухыг алдуулсан нь, үнэн хэрэгтээ, усанд унасан жимсний дуу төдийхөн байсан. Энэхүү үйл явдлаар жишээлж *«аливаа зүйл төсөөлж бодож байснаас нь өөр байх, санасанд хүрэхгүй байх»* зэрэг утга илэрхийлэхэд хэрэглэдэг жишиг хэмжүүр болжээ. Мөн өгүүлэгчийн сэтгэлд хүрэхгүй байх, чамласан үнэлэмж давхар илэрхийлэх болсон аж. Энэ жишээнд хэлний хэмнэлтийн зарчим жинхэнэ утгаараа (бүхэл бүтэн үлгэрээс холбоо үг болтол) хэрэгжжээ гэж үзэж болно.

Дөрөв. «Уһанда үрмэ хүшөөхэ» хэлц үгийн тухай. Усанд өрөм хөшөөх~ загсаах ~ Хар усан дээр өрөм тогтоох зэрэг хувилбар бүхий монголчуудын дунд түгээмэл дэлгэрсэн энэхүү хэлцийн үндсэн хэлбэрийг дараах жишээнээс харъя.

1....Абай — Гэсэр хүбүүн:
 Улаан наранай түһөөтэй
 Урмай-Гоохон хатанаараа
Хара ехэ уһан дээрэ
Үрмэ тогтосор зугаалба
Хабтагай хар шулуун дээрэ

Абай Гэсэр хүү
 Улаан наран мэт
 Урам гоо (Рогмо гуа) хатантайгаа
 Хар их усан дээр
 Өрөм тогтгол ярилцав
 Хавтгай хар чулуун дээр

Ногоо ургасар зугаалба

Боро хоногой болоходо
Шара набшые унахада,
Обоо зөөлэн орондоо
Уушха зөөлэн хүнжэлдөө
Орожо унтаһаниинь тэрэл даа!

Гэсэр, зурбадахи халаа, «Гэсэрэй Архан хара шүдхэрые дараһан тушаа», 211-р тал

2....Хоёр хаадууд ушаража
Морин дээрэһээн буулдаба
Ута гараар ушаража
Уран хүүрээ хэлсэбэ
Урдынхиһаа нааша һануулжа
Удхалан һуужа зугаалба
Харза хара уһан дээрэ
Үрмэ тогтосор зугаалба
(Тунк, Сан ярилцах)
Эльгэн хара шулуун дээрэ
Ногоо ургасар зугаалба...

Гэсэр, дүрбэдэхи халаа, «Гэсэрэй Гал Нурман хааные дараһан тушаа», 247-р тал

3.... Абай Гэсэр хүбүүн
Абга эгэштэеэ хоюулан
Эртынхиһээ нааша дурдажа
Эблүүлэн һуужа зугаалба.
Урдынхиһаа нааша һануулан
Удхалан байжа зугаалба.
Харза хара уһан дээрэ
Үрмэ тогтосор зугаалба.
Эльгэн хара шулуун дээрэ
Ногоо ургасар зугаалба...

Гэсэр, зургаадахи халаа, «Гэсэрэй Шэрэм минаата хааные дараһан тушаа», 356-р тал

«...Харза хара уһан дээрэ
Үрмэ тогтосор зугаалба.
Эльгэн хара шулуун дээрэ
Ногоо ургасар зугаалба...» ,

Ногоо ургатал ярилцав
Бор хоног өнгөрөхөд
Шар навчийг унахад
Овоо зөөлөн орондоо
Уушги зөөлөн хөнжилдөө
Орж унтсан нь тэр юм гэнэ!

...Хоёр хаан уулзаж
Морин дээрээсээ бууцгаав
Урт гараар золгож
Уран үгээ хэлэлцэв
Урьдынхаас нааш сануулж
Учирлан сууж ярилцав
Харз хар усан дээр
Өрөм тогттол ярилцав
Элгэн хар чулуун дээр
Ногоо ургатал ярилцав

Абай Гэсэр хүү
Авга эгчтэйгээ хоёулаа
Эртийнхийг наашлуулан дурдаж
Эвлүүлэн сууж ярилцав
Урьдынхыг наашлуулан сануулж
Учирлан байж ярилцав
Харз хар усан дээр
Өрөм тогттол ярилцав
Элгэн хар чулуун дээр
Ногоо ургатал ярилцав...

«...Хара ехэ уһан дээрэ
Үрмэ тогтосор зугаалба.
Хабтагай хар шулуун дээрэ
Ногоо ургасар зугаалба...» **эльгэн чулуу** —

хаветгай чулуу, хар их ус — харз хар ус гэснээс өөр зөрөөгүй 4 мөр — нэг бадаг шүлэг бүхий хэлц үг буриад Гэсэрийн туужд тохиолдож байна.

Дээр эшилсэн гурван жишээний 1-рт: Гэсэр Архан хар чөтгөрийг ялсны хойно Урам гоо (Рогмо гуа) хатантайгаа учирч суугаад «ярилцаар ... бор хоногууд өнгөрч, шар навчийг унахад унтаж амарсан» гэснээс үзэхэд ямартаа ч нэг улирал дуусах хугацааг илэрхийлсэн байж болох юм. 2-рт: Гал Нурман хаантай дайтахын өмнө уулзаж хэлэлцэж буйг, 3-рт: Гэсэр хүү Шэрэм минаат хааныг дарахаар явах замдаа хар санаат Зутан (Цотон) авгындаа бууж, эхнэртэй нь ярилцаж буйг тус тус уран сайхнаар өгүүлжээ. Эдгээр жишээнд байгаа «**харз хар усан дэ-**

эр..... ногоо ургамал ярилцав» гэсэн хэллэг үндсэндээ Гэсэрийн «*дай дайснаа дарж дархан цолоо олох*» мөчлөг цагийг тодруулсан цаг хугацааны утгат дохио юм. Энэ талаар, С.Дулам: «Монгол үлгэр, домог, туульд баатдын аж амьдралын мөчлөг цаг гэж байна. Эдгээр мөчлөг нь тэдний «*мэндлэх цаг*», «*нэг настай нялх үстэй цаг*», «*хоймсон настай*», «*заяаны зандан дагинаа авах*», «*харьд явахын цаг*», «*дай дайснаа дарж дархан цолоо олох цаг*» гэх зэрэг байж болно» гэж тэмдэглэжээ [6, Н. 165]. Энд өгүүлсэнчлэн, тус хэлц үгийг зөвхөн буриад Гэсэрт биш нийт монголын батаарлаг туулийн «*аж амьдралын мөчлөг цагийн нэг хэсэг буюу дайснаа дарж, дархан цолоо олох*» цагт түгээмэл хэрэглээтэй байдаг.

Дурдсан хэлц үг өнөө цагт хураагдаж хэвшсэний дээр утга багагүй хувьсаж аман ярианд өргөн хэрэглээтэй болж байна. Ямар утгаар хэлэлцэж байна вэ?:

- хар усан дээр өрөм тогтох — бүтэхгүй, биелэгдэшгүй зүйл. Учир зүй, бодит байдлын үүднээс усанд өрөм тогтож, элгэн хад чулуунд өвс ургамал ургадаггүй тул түүнтэй адилтгасан бүтэж биелэхгүй зүйл мөрөөдөх, ярихыг егөөдсөн утга,

- уһанда үрмэ хүшөөхэ — буриад аялгуунд хуурамч царайлах, хуурамч хүний хөөрхий, аман дээрээ л худал ярих... гэсэн утгаар мөн л хэлсэн ярьснаа хэзээ ч биелүүлэхгүй, гадаад байдал нь дотоод мөн чанараасаа эсрэг, зөрчилтэй байхыг шүүмжилсэн өнгө аясаар тус тус хэлэлцэнэ.

Тав. Хэрмэ(хэн) маряатай — Нялх хүүхдийн биеийн жин, байдлыг илэрхийлсэн хэлц үг. Монголчууд ер нь нялх бага хүүхдийг *хөөрхөн, гоё, тарган юм уу туранхай* гэж шууд утгаар хэлэхээс цээрлэдэг уламжлалтай билээ. Энэхүү цээрийн ёсноос улбаалсан эерүүлэх ёстой холбоотой хэлц үг бөгөөд тийм ч их булцгар цулцгар, чанга махтай биш, сулавтар туранхай мах мариа муутай гэхийг энэхүү хэлцээр илэрхийлдэг юм.

Энэ хэлц үгийг: *перен. сухопарый, поджарый, как белка, похожий на белку; хэрмэн маряатай, хэрмэн марья марьяалха. фольк. Становиться поджарым (о коне);* (Шагдаров Л.Д., Черемисов К.М., 2008: 521) гэж мал, амьтанд гол төлөв хэрэглэдэг утга тайлбарлажээ. Түүнчлэн, «хэрмэн марья» гэсэн үгийн үндсэн хувилбар нь баруун буриад буюу булагадуудаас тэмдэглэсэн Гэсэрийн нэг хувилбарг:

...Морин галданаа барижа

Хайр дээгүүр хүтэлжэ

Хатуу туруу туруулба ла

Адха үбһөөр эдеэллэжэ,

Аяга уһаар уһалжа,

Хий газарта уяжа,

Хэрмэн марай марайлуулба ла,

Хуй газарта уяжа,

Хүнэрэ марайндан оруулба ла... (Ганга бүрэд хаан) гэж морины уяа сойлго тааруулахыг «*хий газарт уяж, хэрмэн мариа марайлуулав*» гэсэн дүрслэлт өгүүлбэрээр илэрхийлсэн байна. Угтаа энэ хэлц үг «*хэрэм мэт, хэрэм шиг, хэрэм адил (как белка)*» гэсэн адилтгалаар бүтсэн бөгөөд хэрэм гэдэг амьтны биеийн овор хэмжээний байдалтай нь адилтган зүйрлэжээ. Нөгөө талаас Байгаль далайн баруун биеийн буриад нарын дунд хэлэлцэж байсан нь тэдний амьдарч ирсэн газар нутгийн байдал, ой хөвчтэй холбоотой юм. Улмаар, амнаас ам дамжин улам-

жилсан үлгэр, туулийн хэл, найруулгаас нийт буриадын дунд тархан дэлгэрчээ. Ага, хорийн буриад нар гол төлөв бага хүүхдийн бие, бялдрын хөгжил, байдлыг илэрхийлэхдээ энэ хэлц үгээр хэлэлцэнэ.

Энд мөн л хэлний хэмнэлтийн зарчим бүтээлчээр хэрэгжсэнийг харж болохоор байна. Ер нь, монгол хэлний зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр, өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүдийн холбоо харьцааг таних, ялгах арга хэрэглүүрийн гол үндэс нь хэмнэлийн зарчимтай холбоотой байдаг. Бичгийн найруулга болон ярианы найруулгын тэнцвэрт байдал, ярианы найруулгын аливааг ямагт хэмнэхийг эрмэлзэж байдаг онцлогтой ч холбоотой юм.

16-17-р зууны үед модон барын хэвлэлээр монголчуудын дунд дэлгэрсэн «Элдэв үлгэрийн далай хэмээх судар оршвой» дорно дахины сургаалын зохиолоос хэвшиж тогтсон «*үльгэр далай таһалха, үльгэрэй юүмэнүүд, үлгэрийн далай шиг~болох*» зэрэг хэлц үг бий. Эдгээрийн сүүлийнх нь нийт монголын дунд түгээмэл хэлэлцэх бөгөөд сургаалын зохиолын нэрээр хэрэглээнд хэвшсэн, утгын хувьд болох бүтэхгүй ба адал явдалтай гэсэн утга илэрхийлж байх жишээтэй. Энэ байдлаар аман болон бичгийн зохиол бүтээлээс уламжлан хэвшсэн хэлц үгсийг бүртгэж, утга, хэрэглээний онцлогийг нягтлан үзэх нь сонирхолтой байна.

Дүгнэлт.

1. Буриад аялгуунаа идэвхтэй хэрэглээтэй байгаа цөөн хэдэн хэлц үгийн үүсэл, утга хэрэглээний онцлогийг сурвалжлан үзэхэд тухайн зохиол, бүтээлийн найруулга дахь бүтэц, хэлбэр хэвээрээ уламжилсан нь байхад нөгөө хэсэг нь ихэвчлэн хураагдаж хэвшсэн нь баримтаас харагдаж байна. Энэ бол утгаа хэлний хөгжлийн хууль, зүй тогтол хэлний хэмнэх зарчим, ярианы болон бичгийн хэлний холбоо харьцаанаас хамаарч буй хэрэг юм.

2. Тухайн цаг үеийн нийгмийн байдал, түүхэн үйл явдал, соёл заншил зэрэгт гарсан өөрчлөлт, тухайлбал, буддын шашны зан үйл, уламжлал тодорхой нэг хэлцэд тусгалаа олж хэвшсэн нь хэлний үгийн сан харьцангуй хөдлөнгө байдгийн чухал жишээ болно. Түүнчлэн, нэг үндэстний оюуны соёлын үнэт зүйл нөгөө үндэстэн, угсаатны оюуны соёлын өврөмөц өнгө төрхийг бүрэлдүүлэхэд харилцан нөлөөлсний зэрэгцээ бусдаас ялгаатай, өврөмөц зан үйл болж хэвшсэний илрэлийг ганц нэг хэлц үгийн утгаас гарган тайлбарлах жишээ ч байна. Энэ нь хэлц үг угсаатны оюуны болон эдийн соёлыг тээгч үнэт зүйл, өв байдгийн нэг илрэл мөн.

3. Эрдэнийн сан Субашидаас хэвшсэн хэлц үгийн жишээнээс тухайн угсаатны болон өгүүлэгчийн үнэлэмжийг түлхүү илэрхийлж, аливаа зүйлд үнэлгээ өгөх жишиг хэмжүүр болж хэвшсэн онцлог харагдаж байна. Энд өгүүлсэн жишээгээр хэлц үгийн утга, бүтэц угсаатны оюуны соёл, нийгэм цаг үеийн байдал, хэлний хөгжлийн явцад хэрхэн хувьсаж болдгийг цуваа ба хам цагийн үүднээс судлан тайлбарлах хэрэгтэй.

Ном зүй

1. Аким Г. Монгол хэлний өврөмөц хэлцийн толь. Улаанбаатар, 1999. 211 х.
2. Базаррагчаа.М. Монгол хэлний сүегэр ба найруулбар. Улаанбаатар, 2003. 103 х.
3. Бямбасан П. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Улаанбаатар, 2006. 408 х.
4. Гантогтох Г. Буриад аялгууны толь. Улаанбаатар, 2011. 720 х.
5. Гантогтох Г. Угсаа хэл шинжлэл, сурвалж бичиг, бөө мөргөлийн үг хэллэгийн судлал. II боть. Улаанбаатар, 2018. 416 х.

6. Дулам.С. Монгол бэлгэдэл зүй. IY дэвтэр. Улаанбаатар, 2011. 320 х.
7. Гэсэр / найруулан согсологшо Намжил Балдано. Улаан-Үдэ, 1959. 525 х.
8. Отгонсүрэн Д. Ярианы найруулга соёл. Улаанбаатар, 1979. 80 х.
9. Ошоров С. Г. Буряад хэлэн. Фонетикэ. Лексикэ. Фразеологи. 1-дэхи хуби. Улаан-Үдэ, 2006. 144 х.
10. Телия В. Н. Язык. Семиотика, культура. Русская фразеология. Москва, 1996. 282с.
11. Толстой Н. И., Толстая С. М. Славянская этнолингвистика: вопросы теории. Москва, 2013. 241 с.
12. Төмөрцэрэн Ж. Монгол хэлний үгийн сангийн судлал. Улаанбаатар, 2001. 214 х.
13. Ульгэрэй далай. Буряадта оршуулга Г. Чимитов, Ц. Чимитова. Улаан-Үдэ, 2006. 568 х.
14. Үлгэрийн далай / хөрвүүлсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр. Улаанбаатар, 2013. 380 с.
15. Черемисов К. М. Русско-бурятский словарь. Москва, 1973. 803 с.
16. Шүгэр Ц. Монгол модон барын ном. Улаанбаатар, 1991. 261 х.
17. Эрдэнийн сан Субашид / орч. Цахар гэвш Лувсанчүлтэм. Улаанбаатар, 2009. 207 х.

2024 оны 10-дугаар сарын 5-да өгүүлэл редакцийн зөвлөлд орсон, 2024 оны 10-дугаар сарын 15-да шүүмж гарсан, 2024 оны 10-дугаар сарын 24-дэ хэвлэлд орсон.

On Some Idioms of the Buryat Dialect in Mongolia as Cultural Elements

Tserenchimed Luvsantseren

Ph.D

Mongolian National University of Education

14 Baga Toyruu, 14191 Ulaanbaatar, Mongolia

Tserenchimed@msue.edu.mn

Abstract. Dialects play an important role in enriching Mongolian vocabulary with idiomatic expressions. As language users, we incorporate idioms into our everyday conversational discourse. We can grasp their meanings, regardless of whether they refer to something positive or negative, success or failure. However, we may not know exactly why we use these words in a certain way or the historical, traditional, and cultural context behind these words or expressions. This article examines some idioms that are actively used in the spoken discourse of Buryat dialect speakers in Mongolia but whose meanings may not be fully understood by the younger generation or may even be unknown. Additionally, the article aims to explain their etymology, meaning, and pragmatic specifics, drawing on the stylistics of folklore and Buddhist literature as cultural heritage and intellectual values of the Mongols.

Keywords: idioms, Buryat dialects, oral and written texts, conversational speech, principles of preservation, customs.

For citation

Luvsantseren Tserenchimed. On Some Idioms of the Buryat Dialect in Mongolia as Cultural Elements // Buryat Language and Literature in School. 2024; 3: 48–56 (In Mong)

The article was submitted 05.04.2024; approved after review 15.04.2024; accepted for publication 24.10.2024.